

ӨВӨР МОНГОЛЫН МАЛЧДЫН СОЦИАЛЬ ОРОН ЗАЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТҮҮХЭН ҮЕ ШАТ БА ҮР НӨЛӨӨ

LONG MEI

МУИС-ийн ШУС-ийн Социологи, нийгмийн ажлын тэнхим, докторант
С.Мөнхбаатар

МУИС-ийн ШУС-ийн Социологи, нийгмийн ажлын тэнхим, доктор
Orcid: [0000-0003-0287-1347](https://orcid.org/0000-0003-0287-1347)

Г.Түмэннаст

МУИС-ийн ШУС-ийн Социологи, нийгмийн ажлын тэнхимийн эрхлэгч доктор дэд профессор
Orcid [0000-0003-1594-7486](https://orcid.org/0000-0003-1594-7486)

Abstract : *This article analyzes People's Republic of China's policies and actions regarding livestock grazing in Inner Mongolia. A policy analysis of spatial changes in livestock grazing was conducted, and the current situation and historical overview of the past were reviewed chronologically. In reviewing this social spatial change in Inner Mongolia, we consider it within the context of the overall policies implemented since the Chinese government's "Land and Pasture Ownership" policy, first implemented in 1979, to the present day. Pasture policies and practices have shaped the livelihoods, urbanization, demographic structure, and social change of modern Inner Mongolian herders. This article also compares and analyzes the main Western and Eastern theories and concepts regarding social spatial change, and discusses them within the context of a literature review.*

As for the analytical method, the secondary and policy analysis methods were used.

Keywords: social spatial change, social change, government policy, migration, herders' livelihoods.

1. Удиртгал

Хятад ард улсын хэмжээнд тал нутгийн эзлэх талбай нь бүх газар нутгийн 41 хувийг эзэлж байна. Энэ дундаа Өвөр монголын тал нутгийн эзлэх талбай улсын дотроо нэгдүгээрт байрлах ба 87 сая км² бүхий талбайтай (Ван шоу и ба бусад, 2010). Үүнээс Өвөр монголын орон зайн өөрчлөлтийн тухай судалгаа нь байгаль газар зүйн хувьд чухал утга агуулгатай. Нөгөө талаас сүүлийн жилүүдэд малчдын болон газар тариалангийн бүсэд олон шийдвэр гарч хүмүүс нүүх шилжин суурьших, амьдралын аргаа өөрчлөх нөхцөлүүд олноор үүссэн. Байгаль орчин, социаль амьдралын орчин, хот суурин, хүн ам, соёл сэтгэлгээ гэх мэт нийгмийн олон талт өөрчлөлтүүд богино хугацаанд эрчимтэй явагдаж байна. Малчдын амьдрал орон зайн хувьд авч үзэхэд даяарчлал, хотжилтын урсгал ба хөдөө орон нутгийн бодлогын нөлөөлөл гэх мэтийн олон хүчин зүйлсээс шалтгаалж тасралтгүй өөрчлөгдөж байхын зэрэгцээ түүнээс улбаалан нийгмийн олон тулгамдсан асуудлууд үүсэж байна. Эдгээрийн шалтгаан, үр дагаврыг судлах нь Өвөр монголын орон зайн судалгааны ач холбогдлыг харуулна.

Орон зайн судалгааны эх сурвалжийг ярихад францын шүүмжлэлт үзлийн судлаачийн нэг болох Henri Lefebvre-ийг (Лэфэйр) дурдахгүй байхын аргагүй. Тэрээр “Орон зайн үүсэл” гэх номоороо нийгмийн ухааны судалгааны агуулгыг ихээр баялагжуулснаар үл барам “орон зай бол зайлшгүй нийгмийн бүтээгдэхүүн болно” гэж үзсэн байдаг. Социологичид энэ үзэлтэй санал нэгддэг бөгөөд нийгмийн орон зай судлал нь дотроо олон сонирхолтой асуудлыг агуулдаг бөгөөд үүнийг цаашид дэлгэрүүлэн судлах шаардлагатай гэж үзсэн байдаг. Хятадын судлаачид Марксын үзэл, даяарчлалд,

хотжилт ба мэдээлэл технологи зэрэг олон талаас орон зайн асуудлыг шинжилжээ. Гэхдээ Өвөр монгол орны орон зайн асуудал, тэр дундаа малчдын амьдралын социаль орон зайн асуудлыг хөндсөн судалгаа дутмаг байна.

Тус өгүүллээр дамжуулан орон зайн судалгааны хүрээнд Өвөр монголын малжих орны орон зайн судалгаанд анхаарал хандуулахын зэрэгцээ өөрчлөлтийн хүрээнд үүсч байгаа тулгамдсан асуудлыг тодорхой хэрэгжсэн хэд хэдэн бодлогын үе шатад хуваан, түүний үр нөлөөгөөр тайлбарлан шинжлэхийг зорилоо.

2. Судлагдсан байдлын тойм

Орон зайг нийгмийн ухааны шинжилгээний хүрээнд байгаль газар зүйн орон зай, нийгмийн орон зай гэж ихэвчлэн хуваадаг. Гэхдээ судлаачид улс орон, хотжилт, газар зүй, соёл гэх мэт адил бус олон талаас орон зайг шинжилдэг.

- Хотжилтын талаас Английн судлаач Derek Gregory (Дерек Грегори) орон зайн үүслийн явцдаа нийгмийн харьцаа ба орон зайн бүтцийн хоорондох харьцаа холбоог онцлон судалж, нийгмийн орон зай нь зогсолтгүй өөрчлөгддөгийн зэрэгцээ бас тасралтгүй шинэ орон зайн бүтцийг үүсгэж байдаг үйл явц болно гэж үздэг (Smith, N., 1989).

- Соёлын талаас орон зайг судалсан судлаачид бол Mike Crang (Майк Кранг), Michel Foucault (Мишел Фуко) нар юм. Mike Crang хүмүүсийн өдөр тутмын амьдралд үзүүлэх соёлын байр суурь ба үнэ цэнийг чухалчлан, газар орон болон дэлхийн харилцаа, соёл болон аж ахуйн хоорондох харьцаа гэх мэт олон талаас шинжилжээ (Michael Brown, 2005).

Мишел Фуко соёлын түүхэн талаас орон зайг шинжилж орон зай нь хүмүүсийн өдөр тутмын амьдралын талбар болохоор үл барам, өөрсдийгөө илэрхийлэх хэрэгсэл ч болдог гэжээ (Боо Еэ Мин, 2001).

- Anthony Giddens (Антони Гидденс) бүтцийн онолын үүднээс “Space-time” гэх бүтцийн хүрээг дурдан, тогтсон орон зайн бүтэц нь хүмүүсийн нийгмийн үйлдэлтэй тасралтгүй холбогдож байдаг. Өөрөөр хэлбэл, орон зайн бүтэц нь хүмүүсийн нийгмийн үйлдлийн дунд үүсэж бий болдог ч хүмүүсийн хоорондын харилцаа, харилцан үйлдэл нь дахин шинэ орон зайн бүтцийг бий болгодог гэжээ (George Rizer, 2003).

- Газар зүйн талаас David Harvey (Дэвид Харви) дэлгэрэнгүй судалжээ. Тэрээр орон зай нь эд хөрөнгө, баялгийн төлөөх ангийн тэмцлийн дунд бүрэлддэг ба үүний улмаас газар зүйн орчны тэгш бус байдлыг бий болгодог гэж үзжээ (David Harvey, 2006).

- Мэдээллийн технологийн өндөр хурдтай өөрчлөлт, хөгжлийг дагалдан, мэдээллийн хийсвэр орон зайн үүслийн тухай судлах эрдэмтэд нэмэгдэж байна. Үүний дотор Америкийн судлаач Castells (Кастелл), мэдээлэл технологийн хөгжил нь орон зайг тэлж хийсвэр орон зайн чиг хандлагыг бий болгож байна гэж үзэв (Castells, 1989).

Орон зайн судалгааны талаар Хятадын судлаачдын судалгааны тойм

- Хотын орон зайн өөрчлөлтийн талаас судалсан бүтээл бол Лөө Мин-ын “Орон зайн хүч: газар зүй, улс төр болон хотын хөгжил” (Лөө мин, 2012). Тус номд орон зайг улс төр аж ахуйн талаас Хятад ард улсын хотжилт, орон нутгийн эдийн засгийн хөгжлийн дунд оршиж байгаа асуудлуудыг шинжилсэн байна. Тэрээр газар зүйн орон зай нь хотын хөгжилд нөлөөлөх гол хүчин зүйлс болно гэж үзжээ. Үүнээс

гадна Чэн Вэй “Хотын хорооллын орон зайн эрхийн дүрэм: нийгмийн орон зайн тал” (Чинвий, 2015) гэх номд хотын хорооллын орон зайн өөрчлөлтийн тухай задлан шинжилжээ.

- Марксын онолын талаас орон зайг судалсан бүтээл ч их байдаг. Тухайлбал, Марксын зөрчилдөөний онолын өнцгөөс хотын орон зайн өөрчлөлтийг шинжлэхийг зорьдог. Марксын үзэл нь Хятад ард улсын хотжилтын орон зайн дунд үүсэж байгаа асуудлыг шийдвэрлэхэд чухал хувь нэмэртэй гэж үнэлдэг (Ли Цүн Мин, 2012).

- Мэдээлэл харилцаа холбооны орон зайн талаас Лио Шоо Жий Хятадын мэдээлэл харилцаа холбооны нийгмийн хөгжлийн явцад үзүүлсэн нөлөөг судлан мэдээлэл харилцаа холбооны орон зайн ялгарал, харилцаа, туршлага зэргийг нийгмийн эрх ба уламжлалт соёлын талаас бүтцийн шинжилгээ хийжээ. Тэрээр Хятадын мэдээлэл харилцаа холбооны орон зай нь технологийн мэргэжил ба уламжлалт соёлын нөлөөлөл дор хурдтай хөгжиж байгаа ч ойлголт мэдлэг хангалтгүй, орон зайн хоорондох харилцан үйлдэл дутмаг зэрэг асуудал оршиж байгааг гэж судалгаандаа гаргасан байна (Лио Шоо Жийе, 2019) .

- Хөдөө орон нутгийн буюу малжих тариалах орны орон зайг судалсан судлаач

Ли Лин соёлын талаас Хятадын хөдөө тосгоны олон нийтийн соёлын орон зай дахь нөхцөл байдал, тулгамдсан асуудлыг задлан шинжилж, хөдөө тосгоны олон нийтийн соёлын орон зайд уламжлалт соёлоос гадна бас олон талын шинэ соёлын зүйлс нэвчиж байгааг тодорхойлов (Ли лин, 2021) .

Өвөр монголын орон зайн судалгааны байдал:

Өвөр монгол орны эдийн засаг, малчдын амьдрал, бодлого зэрэгт суурилсан судалгаа олон байдаг. Эдгээр бүтээлд байгаль газар зүй, нийгмийн өөрчлөлт тусгагдаж байдаг ч яг орон зайн өөрчлөлтийг тусгайлан судалсан бүтээл цөөн байна. Орон зайн өөрчлөлтийн талаар нэлээд судалсан бүтээл бол судлаач Эрдэмтийн “Хотоос хот: Өвөр монголын малжих орны амьдралын орон зай буюу хотжилтын тухай шинжилгээ” (хятад хэвлэл)-г дурдах ёстой. Тус судалгаа нь Өвөр монголын малжих орны амьдралын орон зайн өөрчлөлтийг задлан шинжилж, хотжилт хэрхэн малчдын амьдралын орон зайд нөлөөлж байгаа, хотжилтын урсгал дор малжих орны амьдралын орон зай нь хэрхэн зохицох бол, гэх мэт асуудлын тойронд судалсан байна. Тэрээр ямар нэгэн амьдралын орон зайн нөхцөл байдал нь тэр чигээрээ нийгмийн харилцааны орон зайн бүрэлдлийн үр дүн гэж үзсэн байдаг (Эрдэмт, 2022) .

Гадаад улсын орон зайн судалгаан нь нийгмийн шинжлэх ухааны судалгааны хүрээнд нэлээд сайн хөгжиж, өөрийн гэсэн боловсронгуй хөгжлийн төвшинд хүрсэн гэж ойлгож болно. Хятадын орон зайн тухай судалгаан нь ч ерээд оноос эхлэн нэлээд өндөр хурдцаар хөгжсөн. Гэхдээ орон зайн судалгааны объект нь голдуу хот буюу хот хөдөөгийн бүс нутгаар төвлөрч байх нь олонтаа бөгөөд хөдөө орон нутаг тэр дундаа малжих орны орон зайн судалгаа харьцангуй бага байгаа нь тус сэдвийг судлах хэрэгцээ шаардлага өндөр байгааг харуулж байна.

3.Өвөр монголын малчдын социаль орон зайн өөрчлөлтийн үе шат ба тулгамдсан асуудал

Орчин үеийн Хятадын хотжилт буюу эдийн засаг, байгаль орчин зэрэгт чиглүүлсэн бодлогууд нь нэг талаас орон зайн бүтцийн талыг бий болгодог гэж хэлэхэд болох юм. Хятад улсад 1980-аад оны үеийн шинэчлэл нээлттэй бодлогын хэрэгжилтээс хөдөө орон нутагт ялангуяа Өвөр монголын орон зайд авчирсан асар их өөрчлөлт үүнийг гэрчилнэ. Өвөрмонголын орон зайн өөрчлөлтийн асуудлыг дараах гурван үед хуваан авч үзэж болно. Үүнд:

1. Нутаг бэлчээрийг эзэмшүүлэх бодлого (өрхийн гэрээний тогтолцоо) ба орон зайн өөрчлөлт-1980 аад оны үе

Өвөр монголд наяд оны эхээр нутаг бэлчээрийг малчин өрхөд хуваан өгч эзэмшүүлэн, малчин өрх болгон өөрийн гэсэн эзэмших эрх бүхий бэлчээр хадлантай болсон байна. Бас эзэмших эрхийг 30 жилд өөрчлөгдөхгүй гэж тогтсон байдаг. Үүний дагуу нутаг бэлчээрийн зааг хязгаарыг хэмжин тогтоож, өмчлөх эрхийн бичиг баримттай болгосон. Өвөр монголын хошуу нутгийн нутаг бэлчээрийн эзэмших байдал бас хоорондоо зохих ялгаа зөрүүтэй. Зарим газар нь шууд нутаг бэлчээрээ торлон хуваасан бол, бас зарим нутагт эзэмших эрхийн бичиг өгөөд, нутаг бэлчээрийг шууд торлон хашаалсангүй. Гэвч нутаг бэлчээрийг орон зайн хувьд ил буюу далд хэлбэрээр нэгэнт хуваан өөрчилсөн нь үнэн зүйл юм. Энэ байдлаас дараах хэдэн анхаарах зүйл үүссэн гэж үзэж болно. Үүнд:

Нэгт: Юуны өмнө уул усны байц, цаг агаарын байдлыг даган нүүдэл суудал хийдэг амьдралын зан заншилд энэ үеэс эхлэн ихээхэн өөрчлөлт гарсан. Тухайлбал, орон зайн хувьд маш түргэн нүүдэл (transhumance) эсвэл суурьшмал (settlement) гэсэн хэв маяг бий болж эхэлсэн.

Хоёрт: Дараа нь малчдын нутаг бэлчээрийн орон зайн хувьд ч өөрчлөлт авчирсан. Газар нутгийн нэршлийн хувьд ямар нэгэн газрын байц (ямар тал, ямар хөндий гэх мэт)-ээр нутаг усаа нэрийдэг байсан бол өрхийн гэрээний тогтолцоогоос үүдэн хувь хүн буюу малчин өрх (Батын нутаг, Баярын бэлчээр гэх мэт)-ээр нэгж болгон нэрлэх нь олон болсон. Орон зайн хэмжээний талаар газар зүйн нарийн хэмжүүрийг ашиглах болсон. Уламжлалт харилцаанд амьдралын туршлагаар уул тал, ус бэлчээрийн зай хэмжээг төсөөлөн зааг хязгаараа тогтоодог байсан бол өрхийн гэрээний тогтолцоогоос сүүлээр газар зүйн хэм хэмжээг хэмжих багажид түшиглэн нутаг бэлчээр, хадлан зэрэгт улам нарийн хэмжилт хийхийг зорьдог болсон байна.

Гуравт, Малчдын нийгмийн харилцааны талын тулгамдсан асуудал олширсон. Нутаг бэлчээрийн маргаан, гацаа ба малчдын хоорондох зөрчил гэх мэтийн асуудлууд байнга үүсдэг болсон байна. Хэдийгээр энэ үеэс эхлэн малчдын амьдралын идэвхжил ба газар нутгаа хайрлах ухамсар дээшилж, өөрийн эзэгнэх бэлчээр нутгийнхаа хэмжээ дотор хамгийн их үнэ цэнтэй зүйлсийг бүтээхийн төлөө чармайх болсон гэж олонх хүмүүс үнэлдэг ч Өвөр монголын нутаг бэлчээрийн буюу байгаль орчны орон зайн бүтцийн хувьд урьд өмнө байгаагүй хэсэглэгдэн хуваагдсан буюу эрс багассан гэж үздэг.

2. Байгаль орчныг сэргээн хамгаалах бодлого ба орон зайн өөрчлөлт-2000 аад он

1990-ээд оноос эхлэн Өвөр монгол орны ган гачиг ба элсэн шуурганы асуудал зөвхөн малжих орны асуудал төдий биш болжээ. Элсэн шуурганы хор хөнөөл нь Бээжин, Шанхай гэх мэтийн их хотыг ч хамарч, асуудал даамжирч олон төрийн бус байгууллагууд, засгийн газрын анхааралд хүрсэн байна (Ван Шоу И, 2009, 页 3). Ерээд оны эхэнд Хятадын умард хэсэг (ялангуяа, Өвөр монгол) байгаль орчны цөлжсөн газар нутгийн хэмжээ 51 хувийг давав. Бас байгаль орчин муудсан нь малын тоо толгойн олшрол буюу нутаг бэлчээрийн даацаас хэтэртэл малжсаны үр дүн гэсэн үзэл газар авч байлаа. Энэхүү нөхцөл байдлын доор маш олон байгаль орчныг хамгаалах бодлогууд эхлэн бий болсон.

Үүний дунд улсын чанартай бодлогууд нь *нэгдүгээрт* улирлын чанартай малаа хашаалах буюу байгаль орчны хамгаалах үүднээс малчдыг нүүлгэн шилжүүлэх бодлого болно. Хашаалж малжих нь олонхдоо жил болгоны 3-6 дугаар сарын хугацаанд хашаалан малжиж, 6 сараас эхлэн бэлчээрлүүлэхийг тусгасан байна.

Хоёрдугаарт байгаль орчныг хамгаалах үүднээс малчдыг нутаг бэлчээрээс нь нүүлгэн шилжүүлж байлаа. Энэ нь зарим газрын малчдыг нутаг бэлчээрээс нь бүрмөсөн шилжүүлэн нүүлгэж байгаль

орчныг нь сэргээн хамгаалах гэсэн бодлого байсан. Тухайн үед Өвөр монголын хошуу балгасын¹ хажуугаар маш олон малчдыг нүүлгэсэн тосгон бий болсон ч амьдралын хэв маягийн хэт их өөрчлөлт нь олонх малчдыг дахин нутаг уруугаа нүүх хэмжээнд хүргэсэн байна.

Гэхдээ эдгээр бодлогын дагуу малчид нутаг бэлчээрээсээ салах, амин зуулга, амьдрах хэв маяг нь өөрчлөгдөх гэх мэтийн нутаг бэлчээр ба амьдралын орон зайн талд маш олон өөрчлөлтийг авчирсан байна. Үнэндээ Өвөр монголын байгаль орчны тэнцвэр алдаж байгаа нь зөвхөн малын тоо толгойн олширсон шалтгаанаас биш, харин тухайн үеийн ган гачиг үргэлжилсэн цаг агаарын хүндрэлтэй байдал нөгөө талаас гол шалтгаан нь нутаг бэлчээрийн орон зайг хэсэглэн хуваасан бодлогын үр дагавар гэж үзэх болсон.

3. Хот суурины өргөжилт, байгалийн баялгийг нээн ашиглах бодлого ба орон зайн өөрчлөлт-өнөөг хүртэлх үе

Хотжих хөдөлгөөн эрчимжиж 1982-1988 оны үеэр Өвөр Монголд 16 шинэ хот байгуулагдсан. 1988 оноос өнөөдрийг хүртэл "Өрнөдийн хөгжлийн стратеги" хэрэгжиж байна. Өвөр Монголын аж үйлдвэрийн бүс, хөгжлийн бүсүүд тасралтгүй байгуулагдсан бөгөөд нүүрсний томоохон уурхай нэг нэгнийхээ араас хөгжиж байна. Аажмаар, Хөх хот-Бугат-Ордосын цөм болох хот байгуулалт бий болно (Jia Xiaohua, 2017).

2023 онд Өвөр Монгол дахь хотжилтын түвшин хүн амын 64 хувийг хамраад байна. Сүүлийн хориод жилийн турш Өвөр монголын уул уурхайн хөгжил, хөрөнгө оруулалт улам өргөжиж, малжих орны хот хэмээн нэрлэдэг Шилийн хотоор жишээ болгон авч үзэхэд хотын ойр орчмын нүүрсний уурхайн нээлтийг дагалдан малчдын бэлчээр нутаг уул уурхайд хамрагдан, малчид хот руу нүүх, бизнес, худалдаа эрхлэх гэх мэт хүн амын шилжилтийг бий болгосон. Эндээс малчин байсан хүмүүс шинээр худалдаа арилжаа хийх, хот газар ажил эрхлэх нь тэр бүр амжилттай болж чадахгүй байгаагаас ажилгүй болох, амин зуулгаа алдах, эрүүл мэнд, сэтгэл санаагаар унах зэрэг нийгмийн олон сөрөг үзэгдэл бий болсоор байна. Эрчимтэй явагдаж байгаа "хотжуулах" үзэгдэл, шил даран нээгдэж байгаа уул уурхай нь малчдын хүн амын орон зайн өөрчлөлтийг бий болгосон орчин үеийн маш том хүчин зүйл гэж харагдаж байна.

Дүгнэлт

Өвөр монголын орон зайн өөрчлөлт нь богино хугацаанд гэнэт бий болсон өөрчлөлт биш, харин даяаршил, хотжилтын нийтлэг нөлөөгөөр нөхцөлдсөн юм. Аж ахуй, байгаль орчинд нөлөөлөхүйц төрийн бодлогын үр дагавраар хөдөө орон нутгийн хүн амын амьдрал, орон зайд томоохон өөрчлөлт бий болжээ. Нутаг бэлчээрийг эзэмших эрхийн бодлогын нөлөөллөөр Өвөр монголын нутаг бэлчээрийн орон зайн өөрчлөлтийг бий болж, энэхүү нийгмийн өөрчлөлт улам бүр хурдацтай явагдаж байна.

Байгаль орчныг сэргээн хамгаалах нэрийдлийн дор хашаалж малжих, малчдыг нутаг бэлчээрээс нь нүүлгэн шилжүүлэх зэрэг бодлогын нөлөөлөл доор малчдын амьдралын орон зайд ихээхэн өөрчлөлт гарч байна.

Байгалийн баялгийн нээн ашиглалт ба хот суурины өргөжилтийг дагалдан малжих орны хүн амын шилжилт ихээр нэмэгдэж, хүн амын орон зайн өөрчлөлтийг бий болгож байгаа бөгөөд энэ нь улам бүр нэмэгдэх хандлагатай байна.

Малжих орны орон зайн өөрчлөлт нь малчин, малжих амьдрал, байгаль орчны гурамсан холбоо дээр суурилан тогтолцоогоо олдог учир аль нэгнийг нь тусад нь салган авч өөрчлөлтийг шинжлэхэд

¹ Балгас- Монгол хэлний сум гэсэн ойлголттой дүйнэ. Нутаг дэвсгэр, засаг захиргааны нэгжийн нэршил.

хүндрэлтэй байдаг. Иймээс малжих орны газар зүйн болон социаль орон зайн өөрчлөлт нь зөвхөн байгаль газар зүйн ухагдахуун, өөрчлөлт төдий биш, харин малжих орны амьдрал, соёл, нийгмийн харилцааг бүтээж байгаа орчин буюу орон зайн өөрчлөлт мөн.

Ном зүй

Smith N, Keefe P. (1989). *Geography, O'Marx and the Concept of Nature*. Antipode.

Castells Manuel. (1989). *The informational City: information Technology, Economic Restructuring, and the Urban Regional Process*. Oxford, UK, Cambridge, MA: Blackwell.

Чинвий. (2015). Хотын хорооллын эрх дүрэм : нийгмийн орон зайн талын шинжлэл. Хятадын нийгмийн шинжлэх ухааны хүрээлэн.

Боо Еэ Мин (2001). Post-modernization ба газар зүй төр засаг. Шанхайн сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо.

Лөө Мин. (2012). Орон зайн хүчин : газар зүй , Төр засаг ба хотын хөгжил. Шанхайн ардын хэвлэлийн хороо.

Ли Цүн Мин. (2012). Марксын нийгмийн орон зайн судлал. Шанхайн ардын хэвлэлийн хороо.

Лио Шоо Жийе. (2019). Мэдээлэл харилцаа холбоо ба нийгмийн орон зайн өөрчлөлтийн хандлага.: Хятадын ардын их сургуулийн хэвлэлийн хороо.

Ли Лин. (2021). Шинэ цаг үеийн хөдөө орон нутгийн олон нийтийн орон зайн зохиомжил. Хуа Жүн шинжлэх ухааны их сургуулийн хэвлэлийн хороо.

Эрдэмт. (2022). Хогоос хот: Өвөр монголын малжих орны амьдралын орон зай ба хотжилтын шинжлэл. Хятадын нийгмийн шинжлэх ухааны хэвлэлийн хороо.

Ван Шоу И (2009). Байгалийн үзэгдэл доорх малжих орон: Өвөр монголын зургаан гацааны жишээнд. Нийгмийн шинжлэх ухааны хэвлэлийн хороо.

Ван Шоу И ба бусад. (2010). Тэгш бус байдал ба тал нутгийн хамааралтын шинэ сэтгэхүй (Хятад хэвлэл). Хятадын нийгмийн шинжлэх ухааны хүрээлэнгийн хэвлэлийн хороо.

George Rizer. (2003). *The Blackwell Companion to Major Contemporary Social Theorists*. London: Blackwell Publishing.

David Harvey. (2006). Хүслийн орон зай: Нанжин их сургуулийн хэвлэлийн хороо.

Michael Brown. (2005). Соёл газар зүй. Нанжин их сургуулийн хэвлэлийн хороо.

Jia Xiaohua. (2017). Өвөр Монголын бэлчээрийн мал аж ахуйн бүс нутгийн хотжилтын хөгжлийн судалгаа. Бээжин: Хятадын эдийн засгийн хэвлэл.